МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ”

Судалгааны код: **БГСТ-24/017**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: “Дөлгөөнцагаан интернэшнл” ХХК

Улаанбаатар хот
2024

АГУУЛГА

УДИРТГАЛ.....3-5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....5-7
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....8-8
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....8-24
3.1.1. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын баримт бичиг.....8-12
3.1.2. Монгол Улсын Засгийн Газрын өндөр технологи, үндэсний инновацийн талаарх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө.....12-13
3.1.3. Инновацийн тухай хуулийн үйлчлэлийг баталгаажуулах нарийвчлан тогтоох журмын зохицуулалт.....14-18
3.1.4. Инновацийн төсөл хөтөлбөр, гарааны компанийн санхүүжилт.....18-20
3.1.5. Гарааны компанийн зохицуулалт.....20-22
3.1.6. Инновацийн Дэд бүтэц.....22-24
ДӨРӨВ. БУСАД ОРНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....25-36
4.1. Япон улс.....25-29
4.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....29-31
4.3. Оросын Холбооны Улс.....31-33
4.4. Америкийн Нэгдсэн Улс.....33-36
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....37-39
ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ, НОМ ЗҮЙ.....40-41

УДИРТГАЛ

Монгол Улсад 1998 онд анх удаа шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг Монгол Улсын Их хурлын 55 дугаар тогтоолоор батлсан бөгөөд тус тогтоолын хүрээнд Монгол улсад шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг шинэчлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг улс орны хөгжлийн тулгамдсан асуудалд төвлөрүүлэх, салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, шинэ санаа, өндөр технологийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар салбарын хөгжлийг үе шаттай хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлох зорилгоор шинжлэх ухаан, технологи, инновацид чиглэсэн Монгол Улсын урт хугацааны анхны бодлогын баримт бичиг болох “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлсан. Тус төлөвлөгөөнд батлагдсан санхүүгийн тооцооллын хүрээнд дараах үндсэн 6 хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

1. Монгол улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг тогтоох, цөм технологийг тодорхойлох, хэрэгжүүлэх хөтөлбөр
2. Монгол улсын үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр
3. Шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох хөтөлбөр
4. Дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
5. Залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих хөтөлбөр
6. Их сургуулийн судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих хөтөлбөр

Тус мастер төлөвлөгөөний хүрээнд нийт 5 зорилтын хүрээнд 17 стратегийн 24 хүрэх үр дүнг төлөвлөснөөс 7 стратегийн 8 үр дүн зорилтот түвшинд хүрч, 10 стратегийн 16 үр дүн зорилтот түвшинд хүрээгүйгээс 67.0 хувь нь биелээгүй, үр дүнг нэгтгэн тайлагнаагүй байна.[1] Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 2018 онд 88.0 хувиар, 2019 онд 75.1 хувиар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн ч дүгнэлт, зөвлөмж гаргаагүй, үнэлгээний тайланг Засгийн газарт хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, уг төлөвлөгөөний биелэлтэд хөндлөнгийн үнэлгээг олон улсын байгууллага болох Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хийлгэхээр гэрээ байгуулагдсан боловч өнөөдрийг хүртэл тус хөтөлбөрийн биелэлтийн нэгдсэн дүн гараагүй байна.[2]

Дээрх мастер төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 306 дугаар тогтоолоор “Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх 2008-2015 хөтөлбөр”-ийг батлсан бөгөөд тус хөтөлбөрт технологийн инновацад түшиглэн эдийн засгийг шинэчлэх зорилтын хүрээнд дараах стратегиудыг тодорхойлсон байна.

- Стратеги 1. Аж үйлдвэрийн салбарт технологи, инновацийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, технологийн боловсруулалтын түвшнийг гүнзгийрүүлэх хүчин чармайлтыг эдийн засгийн аргаар хөхүүлэн дэмжих, олон улсын технологийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох

[1] Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө, 5 тал, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он

[2] Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, 3 тал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Улаанбаатар хот, 2020 он

замаар эдийн засагт технологийн шинэчлэл хийж өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.

- Стратеги 2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжсэн эрх зүй, зохион байгуулалтын тогтвортой орчныг бүрдүүлнэ.
- Стратеги 3. Монгол Улсын технологийн хөгжлийн чиг хандлагыг тогтоох, урт хугацааны таамаглал (Technology forecast) боловсруулдаг тогтолцоог бүрдүүлнэ.
- Стратеги 4. Үндэсний эдийн засагт судалгаа боловсруулалтын салбарын эзлэх байр суурийг бэхжүүлнэ.

Дээрх стратегиудын хүрээнд дараах 4 дэд хөтөлбөрийг тус бүр зорилтот үзүүлэлт, зорилтот үр дүн санхүүжилтийн тооцооллыг тодорхойлсон.

1. Инновацийн тогтолцоог бүрдүүлэх дэд хөтөлбөр
2. Дэвшилтэт технологийг хөгжүүлэх дэд хөтөлбөр
3. Төрийн өмчийн их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих дэд хөтөлбөр
4. Залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих дэд хөтөлбөр

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж Монгол Улсын Засгийн Газраас боловсруулан Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод “...Цаашид нийгэм, эдийн засгийн бүх хүрээнд инновацийн хандлага улам бүр онцгой үүрэг гүйцэтгэж, мэдлэгийн эдийн засаг гол капитал байх төлөвтэй” хэмээн дүгнэж шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн тэргүүлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Монгол Улс 21 дүгээр зуунд шинжлэх ухааны шинэ мэдлэг, дэвшилтэт технологид суурилан хөгжигч улс байх алсын баримжааг сонгон авч байна.
- Монгол Улс ирэх жилүүдэд боловсрол-шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын үйл ажиллагаанд суурилсан тогтолцоог бүрдүүлэх болон өндөр чадавх эзэмшсэн боловсон хүчнийг бэлтгэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2021 он гэхэд үндэсний инновацийн тогтолцоог төлөвшүүлж “Суралцахуй-Инновац Нийгэмд өгөөжлөх үйлчилгээ”-г холбосон шинэ дэвшилт сэжим бий болгож, бүтээж, ашиглаж ард түмнийхээ амьдралын чанар, аюулгүй байдлыг хангахуйц шинжлэх ухаан технологийн салбартай болно.
- Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын 2021 он хүртэл заавал хэрэгжүүлэх нэн чухал эрхэм зорилго нь шинжлэх ухаан-технологи, инновацийн салбарын үндэсний тэргүүлэх мэргэжилтнийг төрийн онцгой бодлогоор тэтгэн хөгжүүлэх, бэлтгэх хууль зүйн орчныг бүрдүүлж, технологийн авьяас чадварыг дэмжих зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлогын баримт бичгүүдийн хүрээнд 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Инновацийн тухай” хууль батлагдсан бөгөөд батлагдсан цагаас хойш тус хуульд нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

1. 2012 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлт оруулсан байна.
2. 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуультай холбогдуулан хөрөнгө

оруулалтын компанитай холбоотой заалтууд хүчингүй болж, хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлт орсон байна.

3. 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Төрийн захиргааны төв байгууллагын нэршил өөрчлөгдөж холбогдох бүрэн эрхийг нэмэгдүүлсэн байна.
4. 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр санхүүжилтийн бүхий л үйл ажиллагааны эх үүсвэр болох инновацийн сангийн тухай ойлголтыг хуулиас хассан бөгөөд эх үүсвэрийг тодорхойгүй байдлаар үлдээсэн байна.
5. 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотой хууль зөрчсөнтэй холбоотой хариуцлагын асуудал зөрчлийн тухай хуулиар зохицуулагдах болсон байна.
6. 2016 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Төрийн болон албаны нууцын тухай хуультай холбогдуулан хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлт оруулсан байна.
7. 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр агуулгын чанартай буюу гарааны компанийн зохицуулалтууд болон инновацийн дэд бүтэцтэй холбоотой зохицуулалтууд шинээр нэмэгдсэн байна.
8. 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай холбогдуулан хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлтүүд орсон байна.
9. 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай холбогдуулан хууль зүйн техникийн өөрчлөлтүүд орсон байна.
10. 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуультай холбогдуулан хууль зүйн техникийн өөрчлөлтүүд орсон байна.
11. 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Шинжлэх ухаан, технологийн тухай хуультай холбогдуулан хууль зүйн техникийн өөрчлөлтүүд орсон байна.

Инновацийн тухай хууль батлагдан гарснаас хойш Монгол Улсын Их Хурлаас болон Монгол Улсын Засгийн Газраас хөтөлбөр, хөрөнгө оруулалтуудыг баталдаг боловч урт хугацаанд хэрэгждэггүй буюу хөтөлбөрийн дундаас шинэ хөтөлбөр батлагддаг нөхцөл байдалтай байх тул Монгол Улсын Засгийн Газраас баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг нарийвчлалтай тодорхойлох боломжгүй байна. Түүнчлэн олон нийтэд нээлттэй мэдээллүүдээс шүүж үзэхэд Инновацийн тухай хууль 2012 онд батлагдсан цагаасаа хойш хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна.

Үнэлгээ хийсэн аргачлал:

Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Нэг. Төлөвлөх үе шат:

Үнэлгээний эхний үе шат болох төлөвлөх үе шатны хүрээнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох, үнэлэх хэсгийг тогтоох, шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийг сонгох, томьёологдсон шалгуур үзүүлэлтийг боловсруулах, мэдээлэл цуглуулах арга, аргачлалын тогтоох зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэсэн.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох.

Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд дараах нөхцөл байдал үүссэн байх боломжтой тул үнэлгээ хийв.

- Инновацийн тухай хууль 2012 оноос эхлэн үйлчилж эхэлснээс хойш 12 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дах хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан. Хууль тогтоомжийн тухай хууль батлагдсанаас хойш 9 жилийн хугацаанд Инновацийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй байна.
- Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн Газраас баталж хэрэгжүүлсэн инноваци, шинжлэх ухааны талаарх урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн биелэлт, хэрэгжилтийн үнэлгээ хийгдээгүй тул цаашид Монгол улсад өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх, төлөвлөхөд засан сайжруулах шаардлагатай өөрчлөлтүүд ойлгомжгүй байна.

Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь дараах үндсэн асуултад хариулт өгөхөд чиглэнэ.

- Инновацийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалт хуулиар тогтоосон зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа, тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох, урьдчилан тооцоолоогүй бусад үр дагавар гарсан эсэхийг тодорхойлох:
- Хууль хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүсэж байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, гарсан үр өгөөжийн харьцааг тооцох
- Иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлох, хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлох
- Инновацийн тухай хуулийн үр дагавар, нөлөөллийг илрүүлэн, уг хуульд нэмэлт, өөрчлөлт, эсхүл шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлох:

1.2. Үнэлэгдэх хэсгийг тогтоох:

Судалгааны багын зүгээс хуулийн үнэлэгдэх хэсгийг тодорхойлохдоо Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх магадлал өндөртэй зохицуулалтыг олж тогтооход анхаарал хандуулсан. Ингэхдээ бусад судалгааны тайланд тухайлан судлагдсан эрх зүйн зохицуулалтад хэрэгжилтийн үр дагаварт шинжилгээ хийхээс зайлсхийсэн. Иймд Инновацийн тухай хуулийн дараах хэсгийг үнэлгээ хийхээр сонгон авсан.

Бүлэг	Зүйл	Хэсэг	Заалт
Хоёрдугаар бүлэг Инновацийн үйл ажиллагааны удирдлага, төрийн байгууллагын бүрэн эрх	6 дугаар зүйл	1 дэх хэсэг	1 дэх заалт
			6 дах заалт
			7 дах заалт
	12 дугаар зүйл	1 дэх хэсэг	1-9 дэх заалт
Гуравдугаар бүлэг Инновацийн үйл ажиллагаа, төрийн дэмжлэг	16 дугаар зүйл	4 дэх хэсэг	-

1.3. Шалгуур үзүүлэлтийг тогтоох:

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо тухайн үнэлж буй хуулийн зохицуулалтын агуулга, онцлог, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх болсон шалтгааныг харгалзан “Зорилгод хүрсэн түвшин”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал”, “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн гурван шалгуурыг дангаар болон зэрэгцүүлэн сонгон авсан болно.

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д зааснаар зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтод хүрсэн эсэхийг тогтооно. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтээр иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгаа, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгадаг.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг тодорхойлоход харьцуулах хэлбэрийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгохыг эрмэлзсэн. Инновацийн тухай хуулийн үр дагаврын үнэлгээнд хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш, хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш, байх ёстой болон одоо байгаа, тохиолдол судлах гэсэн дөрвөн харьцуулах хэлбэрийг сонгон авсан.

Томьёологдсон шалгуур үзүүлэлтийг боловсруулах:

Энэ нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх, тохирох асуулт тавих ажиллагаа юм. Хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр дагавар нь гарч ирэх байдлаар шалгуур үзүүлэлтийг бичиг боловсруулсан.

Мэдээлэл цуглуулах аргыг тогтоох:

Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхэд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, харьцуулах, томьёологдсон шалгуур үзүүлэлт, асуултад тодорхой хариулт өгөх иргэн, төрийн байгууллага, албан тушаалтантай шууд болон шууд бусаар харилцах хэлбэрээр судалгааны мэдээллийг цуглуулсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд төлөвлөлтийн үед сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажиллагааг гүйцэтгэсэн. Инновацийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхэд хэрэгцээтэй, шаардлагатай ач холбогдол бүхий мэдээллийг олон талт найдвартай эх сурвалжаас цуглуулахад анхаарсан.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд үнэлгээний ажлыг хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг үнэлгээ хийхээр сонгон авсан хүрээнд эцэслэн, үр дүнг нэгтгэн дүгнэж дүгнэлт боловсруулсан. Өмнөх үе шатанд цуглуулсан мэдээллийг хангалттай эсэх, зайлшгүй шаардлагатай буюу хамааралтай эсэх, бодитой эсэхийг үнэлж үзсэн. Тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан хууль тогтоомж хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэхийг судлах, мэдээллийг задлан шинжилсний үндсэн дээр тоон болон чанарын үнэлэлт өгөх, бусад хууль, захиргааны акттай харьцуулах, үнэлгээний үр дүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийн шинжилгээ хийх ажиллагааг хийсэн.

Судалгааны ажлын бүлэг бүр үнэлгээ, үндэслэл, дүгнэлт гэсэн хэсгээс бүрдэнэ. Үнэлгээ хэсэгт тухайн бүлэг, эсхүл үнэлгээний хүрээнд заасан зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн талаар тусган, үнэлгээ хийх болсон үндэслэлийг тодорхойлж, эцэст нь дүгнэлт боловсруулсан.

3.1. Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

3.1.1. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын баримт бичиг

Үнэлэгдэх хэсэг	6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн Газрын бүрэн эрх 6.1.1 дэх заалт
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын баримт бичиг батлагдсан эсэх, батлагдсан баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдал

Инновацийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад "*Төрөөс инновацийн талаар бариmтлах бодлого, хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх*" гэж заасан бөгөөд тухайн заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар болон 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан боловч үндсэн агуулга болох "төрөөс инновацийн талаарх баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж батлах" гэх агуулга өөрчлөгдөөгүй байна. Иймд Инновацийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших Монгол Улсын Засгийн Газар болон Монгол Улсын Их Хурлаас

батлагдсан бодлогын баримт бичгүүдийг судалсан бөгөөд дараах баримт бичгүүд батлагдсан гарсан байна.

3.1.1.1. Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 295 дугаар тогтоолоор “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах 2017-2025 бодлого” батлагдсан бөгөөд тус бодлогын баримт бичиг нь нийт 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 2020 оны жилийн эцсийн үнэлгээгээр нийт 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 15 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 18 арга хэмжээ буюу 42 хувь нь үр дүнд хүрээгүй байна.[3] Үр дүнд хүрээгүй арга хэмжээ дундаас бодлогын баримт бичгийн 4 дүгээр зүйлийн 4.3 дах хэсэгт “*Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг 2016 оноос 2020 онд 2 хувь, 2021 оноос 2025 онд 2.5 хувьд хүргэх*” зорилтын хүрээнд нийт 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч үр дүнд хүрээгүй, шинжлэх ухааны салбарт улсын төсвөөс зарцуулсан санхүүжилт, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2021 оны байдлаар 0.1 хувийг, нийт Монгол Улсын хэмжээнд судалгаа, шинжилгээний зардал 2021 оны байдлаар 0.7 хувийг тус тус эзэлж байх бөгөөд энэ дүн сүүлийн жилүүдэд буурч, тухайн зорилт, арга хэмжээ хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна.[4]

/Зураг 1./ Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх шинжлэх ухааны салбарын зардал



Түүнчлэн бодлогын баримт бичгийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан”-д тайлагнаагүй, 2 жил тутамд дотоод хяналт-шинжилгээ хийгээгүй, засгийн газрын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн талаарх нээлттэй мэдээлэл байхгүй байна.

Тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 379 дугаар тогтоол батлагдсан бөгөөд тус тогтоолоор дараах 6 арга хэмжээ авахыг Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал

[3] Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, 3 тал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Улаанбаатар хот, 2020 он

[4] Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого, 48 тал, Боловсрол, Шинжлэх ухааны яам, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар хот, 2022 он

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу тухайн үеийн Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамд даалгаж шийдвэрлэсэн байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хийгдэх бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийн судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж байх журамд шилжих эрх зүйн орчин бүрдүүлэх арга хэмжээ авах,
- Шинжлэх ухаан, технологийн салбарын онцлогийг харгалзан эрдэм шинжилгээний ажилтанд ур чадварын нэмэгдэл болон зохих мөнгөн дэмжлэгийг сар бүр олгож байх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэх,
- “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” барилга барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах,
- Олон улсад нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн судлаачдад ур чадварын нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгож байх асуудлыг судлан шийдвэрлэх,
- Шинжлэх ухаан, технологийн сан болон их сургуулиудын судалгаа-мэдээллийн санд хадгалагдаж байгаа оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судлан, авах арга хэмжээний санал танилцуулах,
- Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах санал боловсруулж, Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэх,

3.1.1.2. Дээр дурдсанчлан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 233 дугаар тогтоол “Төрөөс инновацийн талаар баримтлах 2018-2025 бодлого”, Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.29 дэх заалтад Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан гаргахаар заасны дагуу инновацийг хөгжүүлэх үндсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны гол чиглэлийг тодорхойлох зорилгыг тусгасан тус бодлогын баримт бичигт нийт 4 зорилт, 25 арга хэмжээ, тус бүр 17 шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлсон. Үүний хүрээнд Боловсрол Соёл, Шинжлэх ухаан, Спортын Сайдын 2019 оны А/145 тушаалаар “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ын I шат (2019-2021 он)-нд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахдаа шаардагдах төсвийг тусгаагүй, хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг батлаагүйгээс шалтгаалж дунд хугацааны бодлогын баримт бичиг хэрэгжих хууль, эрх зүйн орчин бүрдээгүй гэж дүгнэж байна. Энэхүү хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан 4 зорилтын 13 арга хэмжээ буюу 48 хувь нь зорилтот үр дүнд хүрээгүй, нээлттэй мэдээллийн хүрээнд үзэхэд дээрх бодлогын хэрэгжилт, үр дүнг олон нийт болон холбогдох төрийн захиргааны байгууллагад бүрэн тайлагнаагүй байна.

3.1.1.3. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 33 дугаар тогтоолоор “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх 2020-2024 хөтөлбөр”-ийн 3 зорилт, 11 арга хэмжээ, 13 шалгуур үзүүлэлттэй батлагдсан. Боловсрол, Шинжлэх ухааны Сайдын 2020 оны А/190 дүгээр тушаалаар дээрх хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг батлагдсан боловч мөн л хүрэх үр дүнг тодорхойлоогүй,

хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлээгүй, санхүүжилт төлөвлөөгүйгээс шалтгаалж 6 арга хэмжээ буюу 60 хувь нь хэрэгжээгүй байна.Түүнчлэн Боловсрол, Шинжлэх ухааны яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас 2020 он, 2021 онд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлээгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд бүрэн хэрэгжсэнээр тайлагнаж, баталгаажуулсан, бодитоор үнэлгээ хийгээгүй байна.[5]

3.1.1.4. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 162 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 5 зорилт, 22 арга хэмжээг 20 шалгуур үзүүлэлттэй, 2019-2023 онд 2 үе шатаар хэрэгжүүлэхээр баталжээ. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2019 оны А/826 дугаар тушаалаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахдаа шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаагүй, 2020 онд 3.0 тэрбум, 2021 онд 2.5 тэрбум төгрөг зарцуулахаар төсвийн төсөлд саналаа хүргүүлсэн боловч түүний үндэслэл, тооцоолол, хүрэх үр дүнг тодорхойлоогүйгээс төсөвт тусгагдаж батлагдаагүй байна.[6] Түүнчлэн хөтөлбөрийн 3 зорилт, 7 арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “Шинжлэх ухаан, технологийн салбарын захиргааны статистикийн мэдээний маягт, аргачлал”-д, мөн оюуны өмч, патент судлал, инновацийн менежмент, маркетингийн чиглэлийн мэргэжлийг “Боловсролын сургалтын байгууллагын мөрдөх мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн нэр, индексийн жагсаалт”-д тусгаагүйгээс хэрэгжилтийг тооцох, үнэлэх боломжгүй болжээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ суурь түвшин, зорилтот түвшнийг харьцуулаагүй, үр дүнг ерөнхий байдлаар тусгаж, төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан, нөхцөлийг тайлбарлаагүй, тайлагнаагүй байна. Боловсрол, Шинжлэх ухааны яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас хөтөлбөрийн хэрэгжилтийг 2020 онд 72.3 хувийн биелэлттэйгээр гүйцэтгэлийн хувь, хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан байна.[7]

Дүгнэлт

Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт мөрдөж байсан мастер төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхдээ төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгадаггүй, харилцан уялдаа холбоогүй, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үнэлж, үнэлгээнд үндэслэж дараагийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахгүй байгаа нь шинжлэх ухаан, үндэсний инновацийн тогтолцоо хөгжих боломжгүй болсон байна. Түүнчлэн урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөлтийн хэрэгжилтийг харилцан хамаарал, биелэлтийн түвшин, үр нөлөө, гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх, нотлох баримтад тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр бодлогын хэрэгжилтэд цогц хяналт-шинжилгээ хийгээгүй, бодитоор үнэлж дүгнээгүй, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.3,

[5] Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө, 7 тал, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он

[6] Мөн тус тал

[7] хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан, Цахим холбоос https://www.unelgee.gov.mn/ , сүүлд нэвэртсэн огноо 2024.12.25

7.2.4, 7.2.5, 7.2.7-д заасныг баримтлаагүй байна. Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”, Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус хүчингүй болгож, тогтоолын 2-т “...бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг” авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон боловч тус яамнаас дүн шинжилгээ хийгээгүйгээс бодлого, хөтөлбөрийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээг урт, дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичигт тусгаагүй, цаашид хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй болжээ.

3.1.2. Монгол Улсын Засгийн Газрын өндөр технологи, үндэсний инновацийн талаарх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Үнэлэгдэх хэсэг	6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн Газрын бүрэн эрх 6.1.6 дах заалт
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоосон эсэх, хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байдал

Инновацийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дах заалтад “*Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах*” гэж заасан тул хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнүүдэд хэрхэн тусгагдсан талаарх мэдээллийг тодорхойлъё.

3.1.2.1. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шинжлэх ухаан, инновацийн чиглэлийн 12 дугаар хэсэгт “*Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер*” (улсын төсвийн хөрөнгө, 94.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) төсөл, 13 дугаар хэсэгт “*Монгол-Энэтхэг улсын хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах*” (гадаадын зээл, тусламж, 56.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй) төсөл, арга хэмжээг тусгажээ. Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластерийн урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаагүй, барилгын ажлыг эхлүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6 заалтуудыг тус тус зөрчсөн байна.[8] Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад уг төслийг 2021 онд 94.0 тэрбум, 2022 онд 142.8 тэрбум, 2023 онд 154.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тус тус баталсан байна. Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер төслийн хүрээнд лабораторийн 3, оффисын, тусгай зориулалтын, спортын цогцолбор, шинжлэх ухаан, танин мэдэхүйн цогцолбор тус бүр 1, нийт 7 барилгын ажил гүйцэтгүүлэх түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Соёлын яам “Нутгийн буян групп” ХХК, “НБИК” ХХК-ийн түншлэлтэй 3 удаа нэмэлт гэрээ байгуулж, 2023 онд барилгын ажил 41 хувийн гүйцэтгэлтэй, улсын

[8] Боловсрол, Шинжлэх ухааны яамны 2022 оны санхүүгийн аудитын дүгнэлт, 21 тал, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он

төсвөөс 63.2 тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ. [9] Монгол-Энэтхэгийн хамтарсан Мэдээллийн, технологийн аутсорсингийн төв байгуулах төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банктай байгуулсан “Зээлийн хэлэлцээр”-ийг 2012 онд Монгол Улсын Их Хурал “Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулиар баталсан байна. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банктай 3 багц ажлыг гүйцэтгэх 19.7 сая ам.долларын 53372 дугаар зээлийн гэрээг 2012 оны 2 дугаар сард байгуулж, 2023 оны 11 дүгээр сарын байдлаар зөвлөх үйлчилгээний, барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж нийлүүлэх 3 гэрээний хүрээнд нийт 8.9 сая ам.доллар буюу гэрээний үнийн дүнгийн 45.6 хувийг санхүүжүүлсэн байна.[10] Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг 2022 онд дуусгахаар төлөвлөсөн ч 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 20 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зорилтот үр дүнд хүрээгүй байна.

3.1.2.2. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсанаар өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 13 хөрөнгө оруулалт багтсанаас 9 хөрөнгө оруулалт нь боловсролын салбарт чиглэсэн бол үлдсэн 4 хөрөнгө оруулалт нь соёлын салбарт чиглэсэн байна. Үүнээс үзвэл, шинжлэх ухаан, технологийн салбар тэр дундаа Өндөр технологи, үндэсний инновацийн асуудал дээр хөрөнгө оруулалт тусгагдаагүй байна.

3.1.2.3. Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Өндөр технологи, үндэсний инновацийн чиглэлд хөрөнгө оруулалтын төсөл мөн л тусгагдаагүй байна.

Дүгнэлт

2013 оноос хойш буюу инновацийн тухай хууль батлагдсан өдрөөс хойш 2021 онд хүртэл 8 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн Газар Инновацийн тухай хуулийн дээрх холбогдох заалтын хүрээнд өндөр технологи, үндэсний инновацийн чиглэлд хөрөнгө оруулалтыг огт шийдвэрлээгүй байна. Энэхүү хөрөнгө оруулалтыг шийдвэрлээгүй нөхцөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтэд томоохон сөрөг нөлөөлөл үзүүлсэн байна. Харин Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өндөр технологи, үндэсний инновацийн салбарын хүрээнд дээрх 2 барилгын ажлын хөрөнгө оруулалт тусгагдсан боловч өнөөдрийн байдлаар барилгын ажлын явц хангалтгүй гэж Үндэсний аудитын газрын дүгнэлт тусгагдсан байна.

[9] Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө, 13 тал, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он

[10] Мөн тус тал

3.1.3. Инновацийн тухай хуулийн үйлчлэлийг баталгаажуулах нарийвчлан тогтоох журмын зохицуулалт

Үнэлэгдэх хэсэг	6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн Газрын бүрэн эрх 6.1.7 дах заалт
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Инновацийн тухай хуульд тусгагдсан инновацийн хөгжлийг дэмжих, нарийвчлан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмууд батлагдсан эсэх,

Аливаа хууль тогтоомж нийгмийн харилцааг ерөнхийлөн тогтоодог бөгөөд нарийвчлан тодорхойлох асуудлуудыг тухайлсан журмаар зохицуулдаг. Энэ хүрээнд инновацийн тухай хуульд тусгагдсан буюу журмаар нарийвчлан зохицуулахаар тодорхойлсон холбогдох журмууд батлагдсан эсэх талаарх мэдээллийг тодорхойлъё.

3.1.3.1. Инновацийн тухай хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан хуульд тусгайлан заасны дагуу дараах журмууд батлагдах шаардлагатай байна.

№	Инновацийн тухай хуулийн холбогдох зүйл, заалт	Журмын нэр	Батлагдсан огноо	Баталсан этгээд
1	12^1.2. Гарааны компанийн олон нийтэд хувьцаа санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.	Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам	2020.12.09	Санхүүгийн зохицуулах хороо
2	12^1.3. Гарааны компанийн олон нийтэд санал болгох нийт хувьцааны болон нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны үнийн дүнгийн дээд хязгаарыг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.	Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам	2020.12.09	Санхүүгийн зохицуулах хороо

3	13.1.Шинжлэх ухаан, технологийн ололт эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, өндөр үр ашигтай үйлчилгээний төрөл, хэлбэрийг бий болгоход чиглүүлэх, инновацийн үйл ажиллагааны чадавх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн тэргүүлэх чиглэлийг тогтооно. 6.1.2.инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах; 13.4.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн төслийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж өмнөх тэргүүлэх чиглэлийн хугацаа дуусахаас 12 сарын өмнө Засгийн газраар хэлэлцүүлнэ. 13.14.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг төрийн болон төрийн бус байгууллага, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн төлөөллийг оролцуулан Засгийн газрын баталсан журмын дагуу боловсруулна.	Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай	2020.03.18	Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсэх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг
4	14.3.Инновацийн төслийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан журмын дагуу бүртгэнэ. 7.1.9.холбогдох байгууллагатай хамтран инновацийн төслийн	Инновацийн төсөл бүртгэх журам	2019.10.30	Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсэх Боловсрол, соёл, шинжлэх ухаан,

	нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдэд энэ талаар үйлчилгээ үзүүлэх;			спортын сайд Ё.Баатарбилэг
5	15.2.Инновацийн бүтээгдэхүүн энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинжээчдийн дүгнэлтэд үндэслэн гаргана	Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам	2023.06.28	Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-амгалан
6	16.4.Инновацийн дэд бүтэц нь шинжлэх ухааны парк, үйлдвэрлэл технологийн парк, технологи дамжуулах төв, технологийн инкубатор, бизнес-инкубатор, хамтын оффис, менежментийн компаниас бүрдэнэ. Хамтын оффис нь хоорондоо хамааралгүй хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлсэн байх бөгөөд гишүүддээ зориулан зөвлөх, зуучлах, сурталчлах, хөрөнгө оруулалт татах, инновацийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах зэргийг нэгдсэн журмаар зохион байгуулна:	Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам	2023.02.01	Монгол Улсын Ерөнхий Сайд Л.Оюун-эрдэнэ Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-амгалан
7	16.4.1.технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих; 16.4.2.энэ хуулийн 16.4.1-д заасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батлах	Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам	2023.02.01	Монгол Улсын Ерөнхий Сайд Л.Оюун-эрдэнэ Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-амгалан
8	17.1.4.төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын лабораторийн тоног төхөөрөмжөөр инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх	Журам батлагдаагүй		

	компанид хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулах			
9	17.1.11.нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагнал олгох; 17.1.13.үндэсний инновацийн шагналын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай	2018.02.06	Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсүх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа
10	17.2.Энэ хуулийн 17.1.6, 17.1.8, 17.1.9, 17.1.10-т зааснаас бусад инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих хэлбэрийг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна. 17.3.Энэ хуулийн 17.1.1, 17.1.3, 17.1.8, 17.1.11, 17.1.12-т зааснаас бусад инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих хэлбэрийг өндөр технологи, инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулна.	Журам батлагдаагүй		
11	27.1.Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон оюуны өмчийг шинжлэх ухаан, технологийн төсөл санхүүжүүлэх гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн ажлыг гүйцэтгэсэн иргэн болон хуулийн этгээд эзэмшиж болох бөгөөд өмчлүүлэх, эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална.	Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам	2015.06.29	Монгол Улсын Ерөнхий Сайд Ч.Сайханбилэг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр

Дүгнэлт

Инновацийн тухай хуулийг нарийвчлан зохицуулах, цаашлаад төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын харилцааг ойлгомжтой, тодорхой болгох журмын зохицуулалтууд Инновацийн тухай хуулийг батлагдсан гарснаас хойш 8 жилийн дараа буюу 2020 он болон 2023 онд голлох журмын зохицуулалтууд батлагдсан байна. Түүнчлэн батлагдах шаардлагатай журмуудаас өндөр технологий, үндэсний инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулах ёстой хоёр журмыг Монгол Улсын Засгийн Газар өнөөдрийг хүртэл батлаагүй байна. Инновацийн тухай хууль, холбогдох батлагдсан журам нь инновацийн салбарын хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болсон боловч, журмын хэрэгжилт нь төсвийн хязгаарлалт, хөрөнгө оруулалтын дутагдал, судалгаа, хөгжүүлэлт болон грант олгох шалгуур зэрэг шийдвэрлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

3.1.4. Инновацийн төсөл хөтөлбөр, гарааны компанийн санхүүжилт

Үнэлэгдэх хэсэг	12 дугаар зүйл. Инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, хэлбэр 12.1 дэх хэсэг
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгжилт, санхүүжилтийн ил тод байдал

3.1.4.1. Инновацийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу инновацийн төсөл, хөтөлбөр, судалгааг дараах үндэсний болон хувийн эх үүсвэрээс санхүүжүүлж болно гэж заасан. Үүнд

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт (12.1.1);
- Монгол улсын Хөгжлийн банкнаас хөрөнгө (12.1.2);
- Засгийн газрын бусад тусгай сан (12.1.4);
- Хөрөнгө оруулалтын компанийн хөрөнгө (12.1.5);
- Гарааны компанийн анхдагч зах зээлээс босгосон хөрөнгө (12.1.6);
- Инновацад оролцогч талуудын өөрийн хөрөнгө (12.1.7);
- Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив (12.1.8);
- Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр (12.1.9) тус тус багтаж байна.

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэгт заасны дагуу инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрт эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт, буцалтгүй тусламжийн санхүүжилт, инновацийн буцалтгүй тусламж орно гэж заасан боловч олон нийтэд нээлттэй мэдээллийн хүрээнд өнөөдрийн байдлаар эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт олгогдоогүй бөгөөд буцаан төлөх нөхцөлгүй аливаа санхүүжилт нийт санхүүжилтийн эзэлж байна.

Дээр дурдсанчлан Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өндөр технологи, инновацийн төсөл хөтөлбөрт, зориулсан хөрөнгө оруулалт хууль батлагдсан цагаас буюу 2012 оноос 2021 он хүртэл хөрөнгө оруулалт огт хийгдээгүй байна. Орон нутгийн төсвийн хувьд төсвийн төслийг нээлттэй байршуулдаг, Өвөрхангай, дорноговь аймгуудын сүүлийн 3 жилийн төсвийг авч үзэхэд өндөр

технологи, үндэсний инновацийн чиглэлд төсөл хөтөлбөрийг төсөвлөөгүй байна. Харин 2021-2025 оны Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тухайлан Улсын чанартай 2 хөтөлбөр тусгагдсан боловч 2023 оны байдлаар хөрөнгө оруулалтын төслийн явц хангалтгүй байгаа талаар дээр дурдсан болно.

Монгол Улсын Хөгжлийн Банкны санхүүжилтийн хувьд 2017 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш нийт 69 төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн байх бөгөөд үүнээс 31 төсөл нь боловсруулах үйлдвэрийн төсөл, 14 нь барилга, байгууламжийн төсөл, 13 нь уул уурхайн төсөл, 6 нь эрчим хүчний төсөл, 1 тээврийн төсөл, бусад төсөл 4 байна.[11] Үүнээс судлаачдын зүгээс өндөр технологи, үндэсний инноваци шингэсэн төслийг тооцож үзвэл, “Хаягдал батарейг дахин боловсруулах үйлдвэрийн төсөл” 50 хувийн явцтай 2021 онд зогссон, “Дэвшилтэт технологи бүхий эрчим хүчний хэмнэлттэй халаагаар болон бойлуур үйлдвэрлэх төсөл” 50 хувийн явцтай 2018 онд зогссон байна. Иймд Инновацийн тухай хуулийн 12.1.2 дах хэсэгт заасанчлан өндөр технологи, үндэсний инновацийн төслийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсын Засгийн Газрын тусгай сан буюу Шинжлэх ухаан, технологийн сан нь технологи, инновацид суурилсан R&D төслүүдийг санхүүжүүлэх үндэсний сан бөгөөд Монголын судалгаа, хөгжлийн төслүүдийг олон улсын жишигт нийцүүлэн санхүүжүүлэх, хөгжүүлэх замаар Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой бөгөөд энэхүү сангийн хууль эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулиар буюу тус хуулийн 18.3.1, 18.3.2, 18.3.3, 18.3.4, 18.3.6 дахь заалтуудын хүрээнд зохицуулдаг. Тус сан нь шинжлэх ухааны суурь судалгааны төслүүд, R&D төслүүд, инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлж дэмждэг. Өндөр технологи, үндэсний инноваци хариуцсан төрийн захиргааны байгууллага болох Боловсрол, шинжлэх ухааны яам тус сангийн зарцуулалт, хяналтыг хариуцдаг байна.

2018 оноос 2021 онд Шинжлэх ухаан, технологийн сан нь нийт 1520 ширхэг судалгаа, хөгжүүлэлтийн ажилд 24.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин тус сан нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш 2022 он хүртэл нийтдээ 4278 ширхэг судалгаа хөгжүүлэлтийн ажилд 178.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.[12]

2021-2023 онд Шинжлэх ухаан, технологийн сан нь нийт 941 судалгааны ажлыг санхүүжүүлж, 22.6 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.[13] Үүнээс 2021 онд инновацийн 16 төсөл санхүүжүүлсэн бөгөөд нийт санхүүжилтийн дүн 331.2 сая.төгрөг бөгөөд 2022 он болон 2023 онд инновацийн судалгаа, төсөлд санхүүжилт хийгдээгүй байна. Харин 2022 онд 6 төсөл инновацийн грант олгосон бөгөөд нийт санхүүжилтийн дүн 290 сая.төгрөг, 2023 онд 3 төсөлд инновацийн грант олгосон бөгөөд нийт санхүүжилтийн дүн 120 сая.төгрөг байна.[14]

Түүнчлэн тус онуудад тус сангаас төслийн санхүүжилт авсан төрийн өмчийн их сургуулиуд, улсын төсөвт шинжлэх ухааны салбарын эрдэм шинжилгээний

[11] Монгол Улсын Хөгжлийн банкны цахим танилцуулга, 2 тал Монгол Улсын Хөгжлийн банк, цахим холбоос https://dbm.mn/activity/project-program/Project, сүүлд нэвтэрсэн огноо 2025.12.28
[12] 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын хуралдааны мэдээлэл
[13] Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны төсөв, санхүүжилтийн тайлан, Шинжлэх ухаан, тенхологийн сан, Улаанбаатар хот, 2024 он
[14] Шинжлэх ухаан технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2022 он

байгууллага, Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний байгууллагууд нийт 789 судалгаа төслийн 14,8 тэрбум.төгрөгийн судалгаа төслийн санхүүжилтийг авсан бол бусад хувийн их дээл сургуулиуд, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагууд нийтдээ 152 төслийн 2.8 тэрбум.төгрөгийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн байна. Үүнээс үзвэл шинжлэх ухаан технологийн сангаас хувийн судалгааны байгууллага, хувийн сургуулиудад харьцангуй бага хэмжээний төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байна.

Харин 2024 оны Шинжлэх ухаан технологийн сангийн төсвийн хувьд нийт 13.3 тэрбум.төгрөгийн батлагдсан төсөвтэй бөгөөд үүнээс 1.5 тэрбум.төгрөгийг инноваци, өндөр технологийн төслүүдэд зарцуулахаар төсөвлөсөн байна. Гэвч тус төслүүдийн мэдээлэл ил тод байдал харьцангуй бага буюу нийт хэдэн төслийг ямар үнийн дүнгээр санхүүжүүлэх болон урсгал зардлын шинжтэй зардал эсэх нь тодорхойгүй байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан бидний судалгаа хийж байх явцад албан ёсоор гараагүй болно.

Түүнчлэн 1975-2020 оны хооронд ШУТС-аас санхүүжүүлсэн бүх төслүүдийн үр дүнг ихэнх тохиолдолд олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд нийтлэх замаар үр дүнд хүрсэн гэж үзжээ. Үүний үр дүнд 689 шинэ бүтээгдэхүүний загвар, 349 шинэ патент, 284 бүтээгдэхүүний загвар, 148 зохиогчийн эрх зэрэгтэй харьцуулахад олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд 5,832 нийтлэл хэвлэгджээ. Нийт төслийн дөнгөж 17% нь зах зээлд нэвтэрч, үр өгөөж өгсөн гэж дүгнэх боломжтой байна.[15]

Дүгнэлт

Инновацийн тухай хуульд өндөр технологи, үндэсний инновацийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх олон эх үүсвэрийг тусгаж өгсөн боловч өнөөдрийн байдлаар ихэнх төсөл хөтөлбөрийн санхүүжилт зөвхөн Монгол Улсын Засгийн Газрын тусгай сан болох Шинжлэх ухаан, технологийн сангаас олгогдож байна. Гэвч тус сан нь зөвхөн өндөр технологи, үндэсний инновацийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээс гадна, шинжлэх ухааны суурь судалгаанууд болон бусад нарийвчилсан бүхий л судалгааг санхүүжүүлж байна. Өндөр технологи, үндэсний инновацийн төсөл хөтөлбөрүүдэд зарим жилд 120 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт грант олгосон бол зарим жилд 1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь тухайн санхүүжилтийн төлөвлөгөө тогвтортой биш байгааг илэрхийлж байна.

3.1.5. Гарааны компанийн зохицуулалт

Үнэлэгдэх хэсэг	12[1]дүгээр зүйл.Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох 12[1].1 дэх хэсэг
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Гарааны компаниудын хувьцаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох боломж, зохицуулалтын хэрэгжилт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 995 дугаар тогтоолоор “Биржийн бус зах зээлийн үйл ажил ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд журмын 2.1.-д “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн

[15] Монгол Улсын спартап экосистемийн суурь судалгаа, 87 тал, Жайка, Улаанбаатар хот, 2022 он

69 дүгээр зүйлийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.” гэж заасан. Тус байгууллага нь “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага (ҮТББ) юм. Дээрх журмын нийтлэг үндэслэлийн 1.5.-д “Инновацийн тухай хуулийн 12^1 дүгээр зүйл (СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор нэмсэн)-д заасны дагуу холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн гарааны компани нь хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгохтой холбогдсон ерөнхий харилцааг уг журмаар зохицуулна” гэж; мөн журмын 1.6.-д “Гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ журмын 2.5.10-д заасан (СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор нэмсэн) Холбооны журмаар зохицуулна” гэж тус тус заасан байна. Монгол Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Инновацийн тухай хуульд Венч хөрөнгө оруулалтын тухай зохицуулалтуудыг тусгасан байсан. Энэ нь 2013 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаар венч хөрөнгө оруулалтын тухай хэсэг хүчингүй болсон. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу венч хөрөнгө оруулалт нь хаалттай хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой боловч өнөөг хүртэл гарааны бизнесийг дэмжих чиглэлээр хөрөнгө оруулалтын сан амжилттай үйл ажиллагаа явуулсан туршлага хараахан буй болоогүй байна.

Гарааны бизнесийн хөрөнгө оруулалтын хувилбар, боломжууд төдийлөн хангалттай бус байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2019 онд Инновацийн тухай хуульд гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох тухай 12^1 дүгээр зүйлийг нэмсэн. 12^1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гарааны компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.2.-т заасан эрх бүхий байгууллагаар дамжуулан хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгож болно” гэж заасан, тус биржийн бус зах зээлд санал болгох нийт хувьцааны болон нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны үнийн дүнгийн дээд хязгаар болон ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батлаж хэрэгжүүлэхээр зохицуулсан. Инновацийн тухай хуулийн 12^1 дэх заалтын дагуу “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан баталсан бөгөөд цаашид гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах боломжтой болсон.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2024 оны эхний хагас жилийн хугацаанд биржийн бус зах зээлд төгрөгөөр нийт 119 компанийн нийт 3.16 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 211 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 2.45 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Мөн долларoор нийт 94.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 54.4 сая ам долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд төгрөгөөр 53 үнэт цаас гаргагчийн 714.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 62 өрийн хэрэгслийг бүртгэсэн бөгөөд нийт 708.14 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 49.21 хувиар буюу 1.49 дахин өссөн үзүүлэлт юм. Харин тайлант хугацаанд ам долларoор 23.8 сая ам долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 8.9 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн байна.[16] Гэвч үүнд гарааны компанийн санхүүгийн мэдээлэл тусгагдаагүй бөгөөд гарааны компаниуд гараанаасаа холдож чадахгүй байгаагийн илрэл болж байна.

[16] Үнэт цаасны зах зээлийн 2024 оны хагас жилийн тайлан, Санхүүгийн зохицуулах хороо, 9 тал, Улаанбаатар хот 2024 он

Дүгнэлт

Гарааны бизнесийн санхүүжилтийн хэлбэрүүдийг хөгжүүлснээр үе шат бүрд чиглэсэн туршлагатай, мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөгжиж улмаар дараагийн шатны хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгох замаар өөр төсөлд хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлсэн олон оролцогчийн хэрэгцээ шаардлагыг хангасан санхүү, хөрөнгө оруулалтын динамик зохицуулалттай орчин бий болгох. Мөн гарааны компанийн хөрөнгийн зах зээлд олон нийтэд хувьцаа санал болгож гаргахыг дэмжих дэмжлэгийн хэлбэрүүдийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүд болон судалгаанд хамрагдсан салбарын оролцогч компанийн тулгамдсан асуудал, хүлээлтэд нийцүүлж оновчтой тодорхойлох шаардлагатай.

Түүнчлэн Монгол Улсад гарааны компаниуд олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар хөрөнгө оруулалт татах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. “*Хувьцаагаа санал болгож буй гарааны компани нь тодорхой болзол шалгуурыг хангасан тохиолдолд төрөөс тодорхой хувийг санхүүжүүлэх боломжийг бий болгох*.”

3.1.6 Инновацийн Дэд бүтэц

Үнэлэгдэх хэсэг	16 дугаар зүйл.Инновацийн дэд бүтэц 16.4 дэх хэсэг
Шалгуур үзүүлэлт	Практикт хэрэгжсэн байдал, Холбогдох бусад үнэлгээний байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Инновацийн дэд бүтэц нь шинжлэх ухааны парк, үйлдвэрлэл технологийн парк, технологи дамжуулах төв, технологийн инкубатор, бизнес-инкубатор, хамтын оффис, менежментийн компаниас бүрдэнэ. Хамтын оффис нь хоорондоо хамааралгүй хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлсэн байх бөгөөд гишүүддээ зориулан зөвлөх, зуучлах, сурталчлах, хөрөнгө оруулалт татах, инновацийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах зэргийг нэгдсэн журмаар зохион байгуулсан эсэх

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэвшилтэт шатанд гарахын тулд инноваци, шинжлэх ухаан, технологийн салбарын хөгжилд анхаарал хандуулж, төрийн бодлогоор дэмжиж байна. Энэ хүрээнд инновацийн дэд бүтцийн чухал нэг хэсэг болох хамтын оффисууд нь гарааны компаниудын бойжилт, инновацийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд оруулж буй хувь нэмэр болон бизнесийн орчны шинэчлэлд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хамтын оффисын хувьд олон талт үйлчилгээ, үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохион байгуулан, хөрөнгө оруулалт татах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бизнесийн ур чадварыг сайжруулах зэрэг боломжуудыг бий болгох замаар инновацийн орчныг хөгжүүлэх зорилготой. Эдгээр оффисууд нь төрийн болон хувийн секторын хамтын ажиллагааны үр дүнгээр байгуулагдаж, шинжлэх ухаан, технологийн инновациудыг амжилттай хөгжүүлэх нөхцөл бүрдүүлдэг.

Монгол Улс инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хэд хэдэн стратеги, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Шинжлэх Ухаан, Технологийн төвүүд болон паркууд: Засгийн газрын 2017 оны 19 дүгээр тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн сангийн бүтцэд байсан Шинжлэх ухааны паркийн менежментийн хэлтсийг инновац, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл (цаашид Нэгдэл гэх) байгуулсан. Инновацийн тухай хууль, УИХ-ын 2017 оны 17 дугаар тогтоол , 18 дугаар тогтоол , Төрөөс инновацийн талаар 2018-2021 онд баримтлах бодлого , Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд шинжлэх ухааны парк байгуулах талаар тусгасан боловч 2017 оноос хойш 6 жилийн хугацаанд Засгийн газраас шинжлэх ухааны парк байгуулах талаар 2017-2022 оны хөгжлийн бодлогын богино хугацааны төлөвлөлтөд тусгаагүй, тодорхой арга хэмжээ аваагүй байна. БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд лаборатори байгуулах, мэдээллийн сервер, тоног төхөөрөмж нийлүүлэх, технологи дамжуулах платформ байгуулах 3 төсөл хэрэгжүүлсэн боловч “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан технологи үйлдвэрлэлийн нэгдлийн барилга байгууламж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүйгээс төслийн үр дүнд бий болсон лаборатори, дэд бүтцийн платформ, техник, тоног төхөөрөмжийг их сургуулиудад хуваарилсан байна. “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийг байгуулсан боловч харьяа шинжлэх ухааны парк, инновацийн дэд бүтцийн нэгжүүдийг байгуулаагүй, нэгдлийн барилга байгууламж, дэд бүтэц, төсөв хөрөнгийг шийдвэрлээгүйгээс шалтгаалан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг туршиж зүгшрүүлэн үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, инновац, технологи шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх орчин нөхцөл бүрдээгүй байна.
- Технологийн Инкубатор болон Бизнес Инкубатор: Технологийн инкубаторууд нь шинээр үүсэж буй компаниудын хөгжлийг дэмжиж, шаардлагатай боловсон хүчин, санхүү, маркетинг, зөвлөх үйлчилгээ зэргийг олгох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсад Технологийн инкубатор болон Бизнес инкубатор хэд хэдэн байгууллага, төвүүдэд хөгжсөн бөгөөд энэ нь гарааны компаниудад тусламж үзүүлж, тэдний шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлэхэд хэрэгтэй дэмжлэгийг олгодог.
    - Технологийн Инкубатор: Технологийн инкубатор нь хөгжиж буй компаниудын шинэ технологийг амжилттай бүтээх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүжилт татах зэрэгт тусламж үзүүлдэг. Монголд Технологийн инкубаторыг төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаатай байгуулсан байдаг.
    - Бизнес Инкубатор: Бизнес инкубатор нь гарааны бизнесүүдэд мэргэжлийн зөвлөмж, сургалт, санхүүжилт, түншлэл байгуулах зэрэг тусламжийг үзүүлдэг. Монгол Улсад Монголын гарааны бизнесүүдийн төв нь энэ төрлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хамтын оффисууд нь үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орон зай, зөвлөх үйлчилгээ, хөрөнгө оруулалт татах, хамтын ажиллагаа хөгжүүлэх, бизнесийн стратеги боловсруулах зэрэг үйлчилгээгээр дэмждэг мөн олон байгууллага, хувь хүмүүсийн хамтран ажиллах орчныг бүрдүүлдэг. Монгол Улсад одоогоор 5 хамтын оффис хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна гарааны компаниуд, шинжлэх ухаан, инновацийн төсөл хэрэгжүүлэгчдийг нэг дор төвлөрүүлэн, бизнесийн хөгжлийг дэмжин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас инновацийн дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүд нь технологийн шинэчлэлийг дэмжих, инновацийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг олгох зорилготой байдаг.

- Шинжлэх Ухаан, Инновацийн төвийн кластер: 2019 онд болсон Шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хурлаас гаргасан бодлого, шийдвэр, 2020-2024 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийн одоогийн түвшнийг ахиулах, үр дүнг нэмэгдүүлэх, улс орны хөгжлийг хурдасгахад шинжлэх ухааны үр өгөөж, ач холбогдлыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийг дэмжих, судалгааны ажил, инновацийн үйл ажиллагааг дэмжиж, гарааны компаниудыг олноор бий болгох зорилгоор энэхүү бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. Уг цогцолборын барилгад олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториуд, жишиг үйлдвэрлэлийн цех, оффис, номын сан, хурлын заал, спорт заал, олдвор, дээж хадгалах агуулах, палеонтологи, археологи, одон орон судлалын музей зэргийг байрлах бөгөөд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах хүчин чадалтай шинжлэх ухаан, технологи, инноваци, танин мэдэхүйн төв болох юм. Гэвч тус бүтээн байгуулалтын ажил одоог хүртэл дуусаагүй хэвээр байна.
- Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн аутсорсингийн төв: Уг төсөл нь төрийн үйлчилгээг цахимжуулах, хүнд сурталгүй, авлигагүй, цахим засаглалыг бий болгох Засгийн газрын зорилгын хүрээнд хиймэл оюун ухаан, робот, автоматжуулалт, IT, мэдээллийн технологийн чиглэлээр залуусыг бэлтгэх шаардлагатай байгаа. Аутсорсингийн төв нь үүнд ихээхэн хувь нэмрээ оруулах чухал төсөл юм. Энэтхэг улстай хамтран хэрэгжүүлж буй уг төслийн хүрээнд 864м2 талбай бүхий 10 давхар барилга баригдах бөгөөд 700 гаруй хүнийг ажлын байраар хангах юм. Барилгын ажлыг 2022 онд баригдаж дуусхаар төлөвлөсөн хэдийч тус байгууламж баригдсан эсэх болон тус төслийг цаашид хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

Дүгнэлт

Монгол Улсын Инновацийн дэд бүтцийн хэрэгжилт нь технологийн паркууд, инкубаторууд, хамтын оффисууд болон төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжиж байна. Гэвч тус салбарын хөгжил, дэд бүтцийг дэмжихэд асуудлууд байгаа бөгөөд цаашид илүү үр ашигтай, тогтвортой хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын чанар, хяналт, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх үнэлгээ хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай.

ДӨРӨВ. БУСАД ОРНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулах хэлбэрийг сонгох

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3.4-т заасны дагуу Инновацийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг ижил төстэй эрх зүйн хэм, хэмжээтэй харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

4.1. Япон Улс

Япон Улсад инновацийн үйл ажиллагааны харилцааг “Шинжлэх ухааны технологи болон Инновацийн суурь хууль” -аар зохицуулдаг бөгөөд тус үйл ажиллагааг дэмжих харилцааг “Шинжлэх ухааны технологи болон Инновацийн үйл ажиллагааг дэмжих тухай хууль” -аар зохицуулдаг. Шинжлэх ухааны технологи болон Инновацийн суурь хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т “Инновацийн үйл ажиллагаа гэдэг нь шинжлэх ухааны ололт эсхүл нээлт, шинэ бүтээгдэхүүн эсхүл шинэ үйлчилгээний хөгжүүлэлт болон бусад төрлийн бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан шинэ үнэ цэнийг бий болгож, түүнийг нийтийн хүртээл болгох замаар нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг бий болгох үйл ажиллагааг ойлгоно” гэж хуульчилжээ. Тус хуулиуд нь инновацийн үйл ажиллагаа, тэр дундаа инновацийн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг дэмжих харилцааг түлхүү зохицуулсан байдгийг анхаарах нь зүйтэй.

4.1.1. Санхүүжилтийн тухайд

Шинжлэх ухааны технологи болон Инновацийн суурь хуулийн 3 дугаар бүлэгт судалгааны хөгжүүлэлтийг дэмжих зохицуулалтуудыг тусгасан бөгөөд 18 дугаар зүйлд санхүүжилтийн талаар дараах зарчмыг тусгажээ.

18 дугаар зүйл. Судалгааны хөгжүүлэлтэд холбогдох санхүүжилтийг үр ашигтайгаар хэрэглэх тухай “Төр судалгааны хөгжүүлэлтийг саадгүй дэмжихийн тулд, судалгааны хөгжүүлэлтийг боловсронгуй болгоход шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг үр ашигтай, үр дүнтэйгээр хэрэглэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”

Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны судалгаа, улмаар инновацийг дэмжих хүрээнд Япон улсын Засгийн газраас шинжлэх ухааны судалгааны байгууллагууд болон судлаачдад тогтмол санхүүжилтийг олгодог бөгөөд Шинжлэх ухааны технологи болон Инновацийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн хэд хэдэн зохицуулалтуудад санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн талаар зохицуулсан. Тухайлбал,

2 дугаар зүйлийн 15 дах хэсэг. “Энэ хуульд төр гэдэг нь засгийн газар, бие даасан захиргааны хуулийн этгээд болон бусад төрлийн онцгой хуулиар байгуулсан хуулийн этгээдийг ойлгох бөгөөд шинэ технологийг үйлдвэрлэхэд чиглэсэн судалгааны хөгжүүлэлтийн урамшуулал, грант, буцалтгүй тусламжийг олгохоор засгийн газрын журамд заасан этгээдийг ойлгоно.”

Япон Улсад төрөөс олгох санхүүжилтийн олон төрөлтэй ба ямар төрлийн инноваци гэдгээс шалтгаалж санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогддог байна. Энэ хүрээнд Шинжлэх ухааны технологи болон Инновацийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд “*Засгийн газар нь шинжлэх ухааны технологи,*

инновацийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай хууль зүйн, санхүүгийн, татварын болон санхүү, хөрөнгө оруулалтын болон бусад холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай” гэж тусгажээ.

Япон Улсын засгийн газраас шинжлэх ухааны технологийн хөгжүүлэлт болон инновацийг дэмжих зорилготой төсвийг баталдаг бөгөөд энэ нь судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээдийн санхүүжилт, судалгааны хөгжүүлэлтэд шаардлагатай урамшуулал, мөнгөн дэмжлэг, үйл ажиллагааны санхүүжилт зэргээс бүрддэг. Япон Улсын шинжлэх ухааны технологитой холбоотой зардал, санхүүжилтийг “Шинжлэх ухааны технологи, инновацийн хурал”-аас гаргасан төслийн дагуу хэрхэн зарцуулах чиглэлийг тогтоож харьяалах яам тус бүрд байршуулдаг. Япон Улсад Инноваци, шинжлэх ухааны судалгааг дэмжихэд хамгийн их хөрөнгө оруулдаг санхүүжилт нь өрсөлдөөнт судалгааны санхүүжилт юм. Тус санхүүжилтээр тусгай санг байгуулдаг тул тодорхой судалгаа, шинжилгээг олон жилийн турш санхүүжүүлэх боломжтой болдог.[17]

/Зураг 2./ Япон Улсын шинжлэх ухааны технологи, инновацид төрөөс олгох санхүүжилтийг харуулсан бүтэн зураглал



図2−5　　大学等に対する公的資金支援の全体像

4.1.2. Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох

Япон улсад гарааны компанийн хувьцаагаа олон нийтэд санал болгох гэсэн тухайлсан зохицуулалт үгүй. Гэхдээ Шинжлэх ухааны технологи болон Инновацийн

[17] 日本の科学技術・イノベーション政策（2022 年）。

үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 34.4.3 дугаар зүйлд гарааны компанид урамшуулал, буцалтгүй тусламжийг олгох зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ хүрээнд төрөөс гарааны компанийн хувьцааг худалдаж авах боломжийг зохицуулжээ.

34.5 дугаар зүйл. Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд болон төрийн өмчит их сургуулийн хуулийн этгээд нь гарааны компанид санхүүжилт олгохдоо, тухайн гарааны компанийн гаргасан хувьцаа эсхүл хувьцааны опционыг худалдаж авч болно. Энэхүү гарааны компанийн хувьцааг худалдан авах тогтолцоо нь санхүүгийн боломж муутай боловч ирээдүйтэй инновацийн төсөл бүхий гарааны компанид зохих хөрөнгө оруулалтыг хийх, венчур хэлбэрээр гарааны компанийн засаглалыг дэмждэг байна.[18] Уг зохицуулалтад хамаарах гарааны компани нь судалгааны үр дүнгээ инновацийн бүтээгдэхүүн болгож, амжилт олох өндөр магадлалтай компани байх шаардлагатай.

4.1.3. Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих

Шинжлэх ухааны технологи болон Инновацийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 5 дугаар бүлэгт Инновацийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнүүдийн хэлбэрүүдийг дараах байдлаар зохицуулсан.

1) Төр-хувийн хэвшил-эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг дэмжих (5 дугаар бүлэг 1 дүгээр хэсэг)

1.1. Төр-хувийн хэвшил-эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг дэмжих,

Энэ хүрээнд голцуу төрийн өмчит их сургуулийн бүтээсэн мэдлэгийг хувийн хэвшлийн аж ахуйд нэвтрүүлж, инновацийн бүтээгдэхүүн бий болгох замаар тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангахыг зорьдог. Их сургууль болон хувийн хэвшлийн аж ахуйн хамтарсан судалгаа болон их сургуулийн судалгааны үр дүнг хувийн хэвшилд ашиглах тухай холбогдох хуулиудыг баталж хэрэгжүүлдэг.

1.2. Хамтран судалгаа хөгжүүлэлт хийх тохиолдолд зардлыг хуваарилах,

Хуулийн 34.3 дугаар зүйлд зааснаар Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд болон их сургууль нь хувийн хэвшлийн аж ахуйтай хамтарсан судалгааг хийх тохиолдолд хүний нөөцийн зардал, дэд бүтэц, үйл ажиллагааны зардал зэргийг хоорондоо тохиролцож тогтоож болно.

1.3. Гарааны компанид дэмжлэг үзүүлэх,

Хуулийн 34.4 дүгээр зүйлд заасны дагуу судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд болон их сургууль нь гарааны компанид дэд бүтэц, үйл ажиллагаа, оюуны өмчийн шилжүүлэлт, тусгай зөвшөөрөл, зөвлөгөө, зээл болон бусад шаардлагатай асуудлаар дэмжлэг үзүүлж болно.

1.4. Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд болон төрийн өмчит их сургуулийн хуулийн этгээд гарааны компанийн хувьцаа, хувьцааны опционыг худалдан авах,

1.5. Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт,

1.6. Орон нутгийг сэргээн хөгжүүлэх,

Хуулийн 34.7 дугаар зүйлд заасны дагуу засгийн газар эсхүл орон нутгийн захиргааны байгууллага нь бүс нутгийн байгалийн, эдийн

[18] 研究開発法人による出資等に係るガイドライン（平成 31 年）。

засгийн, нийгмийн онцлогт тулгуурласан шинжлэх ухааны технологи, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар бие даасан, өөрийн онцлог бүхий бус нутгийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшил-эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг дэмжих, шинэ инновацийг хөгжүүлж болно.

2) Жижиг дунд компанийн инновацийн үйл ажиллагааг дэмжих (5 дугаар бүлэг 2 дугаар хэсэг)

Хуулийн 34.8 дүгээр зүйлд заасны дагуу жижиг дунд компанийн инновацийг дэмжих зорилгоор төр нь тусгай, шинэ технологийг дэмжих санд холбогдуулан, тухайн жилийн улсын төсвийн төлөвлөгөөг харгалзаж тусгай шинэ технологийн сангийн зорилт, түүнд хүрэх шалгуур үзүүлэлтэд шаардлагатай арга хэмжээг авч болно.

3) Судалгааны хөгжүүлэлтийн дэд бүтцийг хамтран ашиглах (5 дугаар бүлэг 3 дугаар хэсэг)

3.1. Судалгааны хөгжүүлэлтийн дэд бүтцийг хамтран ашиглах болон оюуны өмчийн мэдлэгийг хуваалцахад дэмжих,

Хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу засгийн газар, судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд болон их сургууль нь судалгааг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, оюуны өмчийн мэдлэгийг судалгааны байгууллага болон судлаачдад ашиглуулах арга хэмжээг авна.

3.2. Төрийн дэд бүтцийг ашиглуулах,

Хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу хувийн хэвшлийн судалгааны байгууллага туршилт явуулахад шаардлагатай дэд бүтцийг төрөөс хангаж болно.

4.1.4. Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд

Япон Улсад инновацийн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн судалгааг хөгжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий “Судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээд” гэх захиргааны байгууллага бий. Тус байгууллагыг бие даасан захиргааны хуулийн этгээдийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд дараах байдлаар тодорхойлжээ.[19]

Төрийн үйл ажиллагааны дотроос шинжлэх ухаан, технологийн туршилт, судалгаа, хөгжүүлэлттэй холбоотой бөгөөд тэдгээрийн шинж чанараас хамааран дунд болон урт хугацааны хэтийн төлөвийн хувьд тодорхой хэмжээний бие даасан байдал, бие даасан байдлыг харуулах шаардлагатай. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь Засгийн газраас дэвшүүлсэн дунд болон урт хугацааны үйл ажиллагааны зорилтод хүрэх төлөвлөгөөнд суурилж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны түвшнийг дээшлүүлэх замаар үндэсний эдийн засаг, нийтийн бусад ашиг сонирхлыг зөв зохистой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэнэ. Шинжлэх ухаан, технологи нь Японд хувь нэмрээ оруулахын тулд судалгаа, боловсруулалтын хамгийн их үр дүнг хангах зорилготой бие даасан захиргааны байгууллага. Нэг үгээр хэлбэл, шинжлэх ухаан, судалгааг хөгжүүлэх чиг үүрэгтэй засгийн газрын бие даасан агентлаг юм. Судалгааны чиглэлээс хамаараад тодорхой яамд харьяалагддаг. Жишээ нь хөдөлмөр нийгэм хамгаллын яамд үндэсний хавдрын судалгааны төв харьяалагдаж байгаа бол эдийн засгийн яамд

[19] 独立行政法人通則法の一部を改正する法律

шинэ энерги аж ахуйн технологийн нэгдсэн хөгжүүлэлтийн байгууллага харьяалагдаж байна. Санхүүжилтийн хувьд мэдээж төрөөс эдгээр судалгааны байгууллагуудыг санхүүжүүлдэг.

4.1.5. Паркийн үйл ажиллагаа

Шинжлэх ухааны технологи болон Инновацийн үйл ажиллагааг дэмжих тухай хуульд паркийн үйл ажиллагааны тухай тусгайлан зохицуулаагүй байдаг бөгөөд мөн өөр бусад хуулиудаар паркийн үйл ажиллагааг зохицуулдаг гэж дүгнэхэд хүндрэлтэй байна.

4.1.6. Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах

Япон улсад зарчмын хувьд төрийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг ашиглах тухай тухайлсан зохицуулалт байхгүй бөгөөд оюуны өмчийн холбогдох хууль, дүрэм журмуудад дэлгэрэнгүй зохицуулдаг. Зарчмын хувьд оюуны өмчийг нь төр өмчилдөг бөгөөд тухайн оюуны өмчийг ашиглах этгээд нь улсад роялти төлж оюуны өмчийг ашиглах тусгай зөвшөөрөл авдаг байна.[20]

4.2. БНХАУ

БНХАУ анх 1993 онд “Шинжлэх ухаан, технологийг дэмжих тухай хууль”-ийг баталж, 2007 болон 2021 онд томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулжээ.[21]

4.2.1. Санхүүжилтийн тухайд

БНХАУ-ын засгийн газраас инновацийг дэмжихэд зориулж ихээхэн хэмжээний санхүүжилт болон хөрөнгө оруулалтыг хийдэг ба хуулийн 85 дугаар зүйлд “Тогтвортой хөгжил болон судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс төр нь төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, аж ахуйн хөгжүүлэлт, санхүү, татвар, тендер, хувийн хөрөнгө оруулалт зэрэг асуудлаар бодлого боловсруулна” гэж ерөнхийлөн хуульчилжээ. Түүнчлэн төсвийн санхүүжилт нь дараах төрлийн судалгаануудад түлхүү зарцуулагдах ёстой болохыг хуульчилжээ.

87 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн төсвийн санхүүжилт нь гол төлөв дараах зүйлүүдэд зарцуулагдана:

(1) Судалгаа, хөгжүүлэлтийн суурь нөхцөл болон дэд бүтцийг хөгжүүлэх,
(2) Суурь судалгаа, салбар дундын ахисан түвшний судалгаа,
(3) Эдийн засаг, нийгмийн хөгжилд стратегийн, суурь болон хэтийн төлөвт нөлөөлөх хилийн технологийн судалгаа, олон нийтэд ашигтай технологийн судалгаа, ерөнхий зориулалтын гол технологийн судалгаа,
(4) ерөнхий зориулалтын гол технологиудыг ашиглах, үйлдвэрлэлд өндөр технологийг харуулахуйц ашиглах,
(5) Экологийн орчин, хүмүүсийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой судалгаа шинжилгээ, судалгааны үр дүнг өргөн хүрээнд ашиглах,

---

[20] 大学等における政府資金を原資とする研究開発から生じた知的財産権についての研究ライセンスに関する指針(平成 18 年 5 月 23 日)。

[21] 中华人民共和国科学技术进步法, 修订通过，自 2022 年 1 月 1 日起施行。

(6) Тариалангийн шинэ сорт, хөдөө аж ахуйн технологийн судалгаа шинжилгээ, судалгааны үр дүнг өргөнөөр ашиглах,
(7) шинжлэх ухаан, технологийн боловсон хүчнийг хөгжүүлэх, татах, ашиглах
(8) шинжлэх ухааныг олон нийтэд таниулах.

Энэ хүрээнд БНХАУ-ын төрөөс төрөл бүрийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулан ажилладаг том зургаар харвал санхүүжилт, дэмжлэгийн хувьд дараах төрлүүдтэй.

1. Суурь судалгааг дэмжих сан

16 дугаар зүйл (1). Засгийн газар нь суурь судалгаа болон тэргүүлэх шинжлэх ухааны судалгаа болон мэргэжилтнүүдийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байгалийн шинжлэх ухааны санг байгуулна.

2. Жижиг дунд компанийг дэмжих

16 дугаар зүйл (2). Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд компанийн технологийн инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх инновацийн санг байгуулна.

3. Венчур хөрөнгө оруулалтыг дэмжих

35 дугаар зүйл. Засгийн газар нь бие даасан инновацийг хөгжүүлэх механизм болон өндөр, шинэ технологийн аж ахуйг дэмжих хүрээнд өөрийгөө хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломжтой хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ.

4. Шинжлэх ухааны технологи болон тэргүүлэх салбарт давуу зээл олгохыг дэмжих

18 дугаар зүйл. Засгийн газар нь санхүүгийн байгууллагуудыг оюуны өмч, шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээл олгоход нь дэмжлэг үзүүлэх бөгөөд даатгалын байгууллагуудыг өндөр, шинэ технологийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бий болгоход нь дэмжлэг үзүүлнэ.

5. Татварын хөнгөлөлт үзүүлэх

17 дугаар зүйл. Дараах үйл ажиллагааг хийсэн тохиолдолд, холбогдох зохицуулалтын дагуу татварын давуу нөхцөл, хөнгөлөлт үзүүлнэ.
1) Технологийн хөгжүүлэлт, боловсруулалт, технологийн консалтинг, технологийн үйлчилгээний үйл ажиллагааг гүйцэтгэх,
2) Шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжүүлэлтэд шаардлагатай дотоодод үйлдвэрлэх боломжгүй бараа бүтээгдэхүүнийг импортлох,
3) Төрөөс онцгойлон тогтоосон шинжлэх ухааны технологийн төсөл, төрөөс тогтоосон шинжлэх ухааны стратегийн төслийг хэрэгжүүлэхийн тулд, дотоодод үйлдвэрлэх боломжгүй зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, бараа, хэрэгслийг импортлох,
4) Хууль болон төрийн холбогдох зохицуулалтад тусгаснаар бусад төрлийн шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжүүлэлт, шинжлэх ухааны технологийг бодитоор хэрэгжүүлэх,

6. Бүс нутгийн инноваци

Төр нь шинжлэх ухаан, технологийн нөөцийг бүс нутагт хуваарилах ерөнхий төлөвлөлтийг хийж, үндэсний нөөцийг орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн, бүс нутгийн инновацийг дэмжих олон арга замыг хэрэгжүүлнэ.

/Зураг 3./ БНХАУ-ын инноваци, шинжлэх ухааны санхүүжилтийн хуваарилалтыг харуулсан байдал

FIGURE 1

Sources of S&T funding in China, 2020

RMB billion



Source: Rhodium Group compilation. Commercial sources include companies' own profits reinvested in R&D, as well as external funding through loans and equity investment.

4.2.2. Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох тухай

Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох тухайлсан зохицуулалт БНХАУ-д байхгүй. Гэхдээ БНХАУ-ын төрийн зөвлөлөөс гарааны компанийн венчур хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг баталсан байна. Энэ хүрээнд гарааны компанийн санхүүжилтийг илүү боловсронгуй болгох, нээлттэй болгох, хөгжүүлэх хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгохоор төлөвлөжээ.

4.2.3. Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах

20 дугаар зүйл. Төрийн санхүүжилтээр байгуулагдсан шинжлэх ухааны технологийн сангийн төсөл эсхүл шинжлэх ухааны технологийн стратегийн төслийн хүрээнд бий болсон шинэ патент, компьютерын программын зохиогчийн эрх, ургамлын бүтээгдэхүүний төрлийн эрхийн хувьд төрийн аюулгүй байдал, ашиг сонирхол, нийтийн эрх ашгат онцгой нөлөө үзүүлэхээ бусад тохиолдолд хуулийн дагуу төслийг гүйцэтгэсэн этгээд холбогдох эрхийг олж авах эрхтэй.

4.3. Оросын Холбооны Улс

4.3.1. Инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухайд

Шинжлэх ухаан, шинжлэх ухаан техникийн болон инновацийн үйл ажиллагааг төрөөс, засаг захиргааны нэгжээс, хуулийн этгээд, хувь хүн болон бусад бүхий л хууль тогтоомжид харшлахгүй аргаар хангадаг. Шинжлэх ухаан, инновацийн үйл ажиллагааг дэмжих санг холбооны улс, холбооны улсын гишүүн улсууд, бүс нутаг, хот, автономит бүс нутаг зэрэг нь төсвийн эсвэл бие даасан байгууллагын хэлбэрээр байгуулна. Мөн хувь хүмүүс, хуулийн этгээдүүд ч гэсэн санг байгуулахыг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр сангийн явуулах үйл ажиллагаа, санхүүжүүлэх төслийн

хангасан байх нөхцөл, шаардлага, сонгон шалгаруулалтын талаар нээлттэй байрлуулах мэдээлэл зэрэг нь ОХУ-ын шинжлэх ухаан болон төрийн шинжлэх ухаан, техникийн бодлогын тухай хуулийн 15.1-р зүйлийн 15.1.4, 15.1.6, 15.1.7 дах хэсгүүдээр тодорхойлогддог.

Мөн инновацийн төслийг санхүүжүүлэх нь дунд, жижиг аж ахуй нэгжийг дэмжих, санхүүжилтийг ил тод нээлттэй байлгах, инновацийн үйл ажиллагаагаар дамжуулан холбооны улс болон холбооны улсын бүрэлдэхүүн хэсгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зэрэг зарчимд тулгуурладаг.

ОХУ-ын Шинжлэх ухаан болон төрийн шинжлэх ухаан, техникийн бодлогын тухай хууль (1996) 15-р зүйлийн 15.3 дах хэсэг *“Шинжлэх ухааны суурь судалгаа, хайгуул, судалгааны санхүүжилтийн гол эх үүсвэр нь холбооны улсын төсвийн хөрөнгө, түүнчлэн шинжлэх ухаан, шинжлэх ухаан техник, инновацийн үйл ажиллагааг дэмжих сангийн хөрөнгө байна.”*

4.3.2. Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих

Төрөөс оруулах санхүүжилтийн эх үүсвэр нь шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагуудын төсөв, шинжлэх ухаан, инновацийн үйл ажиллагааг дэмжих сан зэрэг байна. ОХУ-ын төр нь нийт хуульд заасан 9-н аргаар инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой. Мөн холбооны улс нь хамтарсан компанийн болон шууд санхүүжилтийн аргаар хөрөнгө оруулах боломжтой. Ийнхүү инновацийн төслийг санхүүжүүлэхдээ үнэт цаас, эд хөрөнгө болон бусад ОХУ-ын хуульд нийцсэн аргаар хөрөнгө оруулдаг.

4.3.2.1. Хуулийн үндэслэл

ОХУ-ын Шинжлэх ухаан болон төрийн шинжлэх ухаан, техникийн бодлогын тухай хуулийн (1996) 16.2-р зүйлийн 16.2.3 дах хэсэг *“Инновацийн үйл ажиллагаанд төрийн дэмжлэгийг дараах хэлбэрээр олгож болно:*

- *Татвар, хураамж, гаалийн татвар төлөхөд хөнгөлөлт үзүүлэх;*
- *Боловсролын үйлчилгээ үзүүлэх;*
- *Мэдээллийн дэмжлэг үзүүлэх;*
- *Зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төслийн баримт бичгийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх;*
- *Шинэлэг бүтээгдэхүүний эрэлтийг бий болгох;*
- *Санхүүгийн дэмжлэг (төсвийн хөрөнгө оруулалт, татаас, буцалтгүй тусламж, зээл, зээл, баталгаа, дүрмийн санд оруулсан хувь нэмэр орно);*
- *Холбооны улсын хөтөлбөрийн хүрээнд зорилтот хөтөлбөр, дэд хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;*
- *Экспортыг дэмжих;*
- *Дэд бүтцээр хангах;”*

Мөн хуулийн 2020 онд орсон нэмэлт 16-р зүйлийн 16.4 дэх хэсэг *“Инновацийн төслийн санхүүжилтийг хангахдаа хамтарсан компаниар болон инновацийн төслийг шууд санхүүжүүлэх ба үнэт цаас, мөнгөн дүнгээр үнэлэгдэх эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, ашиг олох болон өөр ашигтай үр дүнд хүрэхийн тулд*

бизнес эрхлэх болон бусад үйл ажиллагааны объектоор, бусад аргаар оруулж болно.”

4.3.3. Инновацийн дэд бүтэц

Инновацийн дэд бүтцийн тухай ОХУ-ын судлаачид ялгаатай байдлаар тодорхойлдог ба хууль эрх зүйн орчинд нэгдсэн тодорхойлолт байдаггүй. Тухайлбал, 1996 оны ОХУ-ын Шинжлэх ухаан болон төрийн шинжлэх ухаан, техникийн бодлогын тухай хуулийн 2-р зүйлд “инновацийн дэд бүтэц нь инновацийн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бүхий л байгууллагын цогц бөгөөд удирдлага, тээвэр логистик, санхүү, мэдээлэл, боловсон хүчин, зөвлөх, зохион байгуулалтын үйлчилгээ зэрэг багтана.”-гэж тодорхойлсон байдаг.

Харин 2008 оны ОХУ-ын Засгийн Газрын 1662-р тогтоол “ОХУ-ын 2020 он хүртэлх урт хугацааны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал”-аар “Эдийн засаг, нийгмийн амьдралын бүх давхаргад боловсрол, шинжлэх ухаан, шинжлэх ухааны харилцан үйлчлэлийг хангах мэдлэг, технологи, хууль эрх зүй, санхүү, нийгмийн шинж чанартай институтийн цогцолборыг арилжааны хэлбэрээр хэрэгжүүлэх ашгийн болон ашгийн бус байгууллагыг” инновацийн дэд бүтцийн хүрээнд авч үздэг.

4.3.4. Паркийн үйл ажиллагаа

ОХУ-д хувийн болон төрийн санхүүжилтээр байгуулагдсан олон тооны мэдээлэл технологийн паркууд үйл ажиллагаагаа явуулдаг. "ОХУ-ын аж үйлдвэрийн бодлогын тухай" ОХУ-ын хуулиар холбооны улсын гишүүн улсууд, бүс нутаг, хот, автономит бүс нутаг зэрэгт технологийн парк, паркуудыг удирдан явуулах компаниудад тавигдах шаардлага, өндөр технологийн салбар дах паркт тавигдах шаардлагыг тогтоох бүрэн эрхийг өгсөн байдаг.

4.3.4.1. Хуулийн үндэслэл

"ОХУ-ын аж үйлдвэрийн бодлогын тухай хууль"-ийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсэг:

“ОХУ-ын бүрдүүлэгч сүбъектүүдийн төрийн байгууллагуудын аж үйлдвэрийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх бүрэн эрхэд дараах зүйлс орно:

-5) аж үйлдвэрийн (үйлдвэрлэлийн) паркууд, аж үйлдвэрийн (үйлдвэрлэлийн) паркийн менежментийн компаниуд, аж үйлдвэрийн технологийн паркуудын менежментийн компаниуд, өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг технологийн паркуудийн менежментийн компаниуд, технологийн паркуудын менежментийн компаниудад нэмэлт шаардлага тавих. ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийн төсвийн хөрөнгө, хөрөнгөөр аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээ авах зорилгоор өндөр технологи, үйлдвэрлэлийн кластерууд, үйлдвэрлэлийн кластеруудын төрөлжсөн байгууллагууд;

4.4. Америкийн нэгдсэн улс

АНУ-д шинжлэх ухааны технологи, инновацийг дэмжих харилцааг хэд хэдэн хууль, бодлогын баримт бичгээр зохицуулдаг бөгөөд хамгийн сүүлд 2021 онд Инноваци болон өрсөлдөөний тухай хууль (United States Innovation and Competition Act 2021 S.1260)-ийг баталжээ. Тус хууль нь 2022 оноос 2026 онд АНУ-ын семикондакторын

үйлдвэрлэл, судалгааны хөгжүүлэлт, ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хангах зорилготой.

4.4.1. Санхүүжилтийн тухайд

АНУ-д инновацийг санхүүжүүлэх олон төрлийн механизм бий бөгөөд төрөөс олгох санхүүжилтийн хувьд жижиг бизнесийн инновацийн судалгаа (Small Business Innovation Research) болон жижиг бизнесийн технологийн шилжүүлэлт (Small Business Technology Transfer) гэх төслүүд томоохон байр суурийг эзэлдэг.

Жижиг бизнесийн тухай хууль (Small Business Act)-ийн 9 дүгээр зүйлийн b.4-т Холбооны агентлаг нь жижиг бизнесийн инновацийн судалгааны төсөл болон жижиг бизнесийн технологийн шилжүүлэлтийн төслийг хариуцан ажиллаж холбогдох санхүүжилтийг олгохоор хуульчилжээ. Ингэхдээ жижиг бизнесийн инновацаас арилжааны эргэлтэд орох боломжтой инновацад төвлөрдөг байна.

Жижиг бизнесийн инновацийн судалгааны санхүүжилт нь гурван үе шаттай ба эхний шатанд инновацийн судалгаа, санаагаа баталгаажуулах зорилгоор санхүүжилт авч, хоёр дах шатанд технологийн хөгжүүлэлтээ хийх зорилгоор санхүүжилт авч, гурав дахь шатанд инновацийн бүтээгдэхүүнээ арилжааны эргэлтэд оруулдаг.

Жижиг бизнесийн технологийн шилжүүлэлт гэдэг нь шинжлэх ухааны технологи, туршилт судалгааны үр дүнд бий болсон өгөгдөл, дизайн, бүтээл, программ хангамж, худалдааны нууц зэргийг нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлэх үйл явц юм бөгөөд Жижиг бизнесийн технологийн шилжүүлэлтийн хөтөлбөр нь энэ төрлийн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Жижиг бизнесийн инновацийг дэмжих дээрх хөтөлбөрийн гол шаардлага нь инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах явдал мөн.Үндэсний шинжлэх ухааны холбоо, Үндэсний Эрүүл мэндийн институци зэрэг төрөл бүрийн шинжлэх ухааны байгууллагууд нь өөрсдийн харьяалах салбартаа судлаач болон судалгааны байгууллагуудад грант тогтмол олгодог.

/Зураг 4./ Судалгааны хөгжүүлэлтийн санхүүжилтийн хэмжээ болон төрийн санхүүжилт эзлэх хувь



4.4.2. Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох

АНУ-д гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох бүрэн боломжтой бөгөөд бусад компанийн адил үнэт цаасны холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгодог.

4.4.3. Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих

Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих олон төрөл бий. Түрүүн дурдсанчлан жижиг бизнесийн инновацийг дэмжих төсөл болон шинжлэх ухааны байгууллагуудын грантаас гадна татварын хөнгөлөлт, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах инновац, оюуны өмчийг хамгаалах, инновацийг хурдасгах төсөл, инновацийг концесс, хөнгөлөлттэй зээл олгох, тухайлсан салбарын инновацийг дэмжих хөтөлбөрүүд, муж улсын засаг захиргааны инновацийг дэмжих хөтөлбөр зэрэг олон төсөл, хөтөлбөр хэрэгждэг.

Татварын хуулийн 41 дүгээр зүйлд судалгааны хөгжүүлэлтэд зарцуулсан зардлыг татвараас хөнгөлөх, кредит цуглуулах тогтолцоог хуульчилсан. Энэ төрлийн хөнгөлөлтийг эдлэх судалгааны үйл ажиллагаанд дараах дөрвөн шалгуурыг тавьдаг.

1. Судалгааны үйл ажиллагаа нь бизнесийн бүтээгдэхүүн, үйл явц, бүтээл, төхөөрөмжийн хувьд зайлшгүй ач холбогдолтой үйлчилгээ, чанар, найдвартай байдлыг нэвтрүүлсэн байх,
2. Тодорхойгүй байдлыг үгүй хийсэн байх буюу тухайн инновацийн хөгжүүлэлттэй холбоотой хангалттай мэдээлэлтэй байх,
3. Туршилтаар баталгаажсан байх,
4. Технологид суурилсан шинжлэх ухааны шинжтэй байх,

4.4.4. Паркийн үйл ажиллагаа

АНУ-ын паркын тухайд тухайлсан хууль байхгүй боловч АНУ-ын шинжлэх ухааны паркууд нь дэлхийд тэргүүлдэг. АНУ-ын шинжлэх ухааны паркийн онцлог нь ихэвчлэн их сургуультай нягт уялдаа холбоотой, хамтран ажилладаг бөгөөд технологийн шилжүүлэлт болон судалгааны арилжааны эргэлтэд голчлон төвлөрдөг. Шинжлэх ухааны парк нь төр хувийн хэвшлийн түншлэлээр санхүүждэг. Үйл ажиллагааны хувьд технологийн шилжүүлэлтээс авхуулаад санхүүжилт босгох, менторшип хөтөлбөр, барилга байгууламжийг дундаа ашиглах гэх мэт үйлчилгээнүүдийг үзүүлдэг.

4.4.5. Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах

1980 онд батлагдсан патент болон барааны тэмдгийн тухай хуулиар холбооны засгийн газрын санхүүжилттэй судалгаа, инновацийн бүтээлийн оюуны өмчийн эрхийг тухайн инновацийг хийж гүйцэтгэсэн хүнд олгохыг хүлээн зөвшөөрчээ. Өмнө нь АНУ-д төрийн санхүүжилттэй оюуны өмчийн бүтээлийг төр өмчилж захиран зарцуулах эрхтэй байсан бол тухайн оюуны өмчийн бүтээлийг бий болгоход чиглэсэн ажил, судалгааг хийж гүйцэтгэсэн жижиг дунд бизнес, их сургууль, судлаачид нь оюуны өмчийн бүтээлээ өмчлөх эрхтэй болжээ. Түүнчлэн, тус хууль нь технологийн шилжүүлэлт, патент, хамтран судалгаа хийх зэрэг асуудлуудыг зохицуулдаг.

ТАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Боловсрол, шинжлэх ухааны яам нь 2022 он хүртэл Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байсан. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам нь өндөр технологи, үндэсний инновацийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болсон. Шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яам, Дижитал хөгжил, харилцаа холбооны яам стартапын экосистемийг хөгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжүүдийнхээ бүтцийг хараахан тодорхойлоогүй байна. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогод 2020 он хүртэл өөрчлөлт оруулсан ч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу 2021 онд бүгдийг нь цуцалсан. Тиймээс одоогоор стартапыг хариуцах төрийн тодорхой байгууллага, газар, агентлаг тодорхойгүй бөгөөд Холбогдох яам, агентлагуудын стартапын экосистемийн талаарх мэдлэг, ойлголт хязгаарлагдмал, оролцоо, оролцоо бага байна.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт мөрдөж байсан мастер төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхдээ төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгадаггүй, харилцан уялдаа холбоогүй, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үнэлж, үнэлгээнд үндэслэж дараагийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахгүй байгаа нь шинжлэх ухаан, үндэсний инновацийн тогтолцоо хөгжих боломжгүй болсон байна. Түүнчлэн урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөлтийн хэрэгжилтийг харилцан хамаарал, биелэлтийн түвшин, үр нөлөө, гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх, нотлох баримтад тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр бодлогын хэрэгжилтэд цогц хяналт-шинжилгээ хийгээгүй, бодитоор үнэлж дүгнээгүй, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.3, 7.2.4, 7.2.5, 7.2.7-д заасныг баримтлаагүй байна. Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”, Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус хүчингүй болгож, тогтоолын 2-т “...бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг” авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон боловч тус яамнаас дүн шинжилгээ хийгээгүйгээс бодлого, хөтөлбөрийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээг урт, дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичигт тусгаагүй, цаашид хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй болжээ.

2013 оноос хойш буюу инновацийн тухай хууль батлагдсан өдрөөс хойш 2021 онд хүртэл 8 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн Газар Инновацийн тухай хуулийн дээрх холбогдох заалтын хүрээнд өндөр технологи, үндэсний инновацийн чиглэлд хөрөнгө оруулалтыг огт шийдвэрлээгүй байна. Энэхүү хөрөнгө оруулалтыг шийдвэрлээгүй нөхцөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтэд томоохон сөрөг нөлөөлөл үзүүлсэн байна. Харин Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өндөр технологи, үндэсний инновацийн салбарын хүрээнд дээрх 2 барилгын ажлын хөрөнгө оруулалт тусгагдсан боловч өнөөдрийн байдлаар барилгын ажлын явц хангалтгүй гэж Үндэсний аудитын газрын дүгнэлт тусгагдсан байна.

Инновацийн тухай хуулийг нарийвчлан зохицуулах, цаашлаад төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын харилцааг ойлгомжтой, тодорхой болгох журмын зохицуулалтууд Инновацийн тухай хуулийг батлагдсан гарснаас хойш 8 жилийн дараа буюу 2020 он болон 2023 онд голлох журмын зохицуулалтууд батлагдсан байна. Түүнчлэн батлагдах шаардлагатай журмуудаас өндөр технологий, үндэсний инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулах ёстой хоёр журмыг Монгол Улсын Засгийн Газар өнөөдрийг хүртэл батлаагүй байна. Инновацийн тухай хууль, холбогдох батлагдсан журам нь инновацийн салбарын хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл болсон боловч, журмын хэрэгжилт нь төсвийн хязгаарлалт, хөрөнгө оруулалтын дутагдал, судалгаа, хөгжүүлэлт болон грант олгох шалгуур зэрэг шийдвэрлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

Инновацийн тухай хуульд өндөр технологи, үндэсний инновацийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх олон эх үүсвэрийг тусгаж өгсөн боловч өнөөдрийн байдлаар ихэнх төсөл хөтөлбөрийн санхүүжилт зөвхөн Монгол Улсын Засгийн Газрын тусгай сан болох Шинжлэх ухаан, технологийн сангаас олгогдож байна. Гэвч тус сан нь зөвхөн өндөр технологи, үндэсний инновацийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээс гадна, шинжлэх ухааны суурь судалгаанууд болон бусад нарийвчилсан бүхий л судалгааг санхүүжүүлж байна. Өндөр технологи, үндэсний инновацийн төсөл хөтөлбөрүүдэд зарим жилд 120 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт грант олгосон бол зарим жилд 1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь тухайн санхүүжилтийн төлөвлөгөө тогвтортой биш байгааг илэрхийлж байна.

Монгол Улсын Инновацийн дэд бүтцийн хэрэгжилт нь технологийн паркууд, инкубаторууд, хамтын оффисууд болон төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжиж байна. Гэвч тус салбарын хөгжил, дэд бүтцийг дэмжихэд асуудлууд байгаа бөгөөд цаашид илүү үр ашигтай, тогтвортой хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын чанар, хяналт, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх үнэлгээ хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай.

Гарааны бизнесийн санхүүжилтийн хэлбэрүүдийг хөгжүүлснээр үе шат бүрд чиглэсэн туршлагатай, мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөгжиж улмаар дараагийн шатны хөрөнгө оруулагчдад хувьцаагаа санал болгох замаар өөр төсөлд хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлсэн олон оролцогчийн хэрэгцээ шаардлагыг хангасан санхүү, хөрөнгө оруулалтын динамик зохицуулалттай орчин бий болгох. Мөн гарааны компанийн хөрөнгийн зах зээлд олон нийтэд хувьцаа санал болгож гаргахыг дэмжих дэмжлэгийн хэлбэрүүдийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүд болон судалгаанд хамрагдсан салбарын оролцогч компанийн тулгамдсан асуудал, хүлээлтэд нийцүүлж оновчтой тодорхойлох шаардлагатай.

Түүнчлэн Монгол Улсад гарааны компаниуд олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар хөрөнгө оруулалт татах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. “*Хувьцаагаа санал болгож буй гарааны компани нь тодорхой болзол шалгуурыг хангасан тохиолдолд төрөөс тодорхой хувийг санхүүжүүлэх боломжийг бий болгох*.”

Гадаад улсуудын инновацийн эрх зүйн орчныг ерөнхийд нь тоймлон авч үзэхэд шинжлэх ухаан, технологийн харилцааг түлхүү зохицуулж байна. Харин

тухайн шинжлэх ухааны судалгаа, туршилтын үр дүнд бий болох инноваци нь энэхүү шинжлэх ухааны судалгааны нэг бүрэлдэхүүн, үр дагавар гэж ойлгогдож байна.

Инновацийн санхүүжилтийн хувьд төрөөс инновацид хөрөнгө оруулах тусгай сан байгуулах, судалгааны хөгжүүлэлтийн хуулийн этгээдээр дамжуулан хөрөнгө оруулах, судалгааны үйл ажиллагааны зардлын санхүүжилт, өрсөлдөөнт санхүүжилт буюу тендер, татварын хөнгөлөлт зэрэг төрөл бүрийн санхүүжилтийг олгож байна. Хамгийн түгээмэл олгогддог санхүүжилтийн хэлбэр нь инновацийн холбогдох судалгааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай урсгал санхүүжилтийг олгох явдал байна. Түүнчлэн төр өрсөлдөөнт судалгааны төсөл шалгаруулах буюу грант олгох нь инновацийг санхүүжүүлэх чухал хөшүүрэг болдог байна.

Гарааны компани хувьцаагаа нийтэд санал болгох талаар тухайлсан зохицуулалттай улс байхгүй байна. Харин гарааны компани хувьцаагаа нийтэд санал болгоход дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд гарааны компанийн венчур хөрөнгө оруулалтыг дэмжих тухай зохицуулалтыг тусгасан байна. Мөн зарим тохиолдолд төрийн эрдэм шинжилгээний байгууллага гарааны компанийн тодорхой хувийн хувьцааг эзэмшиж менежментийн удирдлага, арга зүйгээр хангадаг байна.

Шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааны хувьд улс бүрд шинжлэх ухааны паркууд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байх бөгөөд шинжлэх ухааны паркын үйл ажиллагааг тухайлсан зохицуулсан эрх зүйн орчин бий гэж хэлэхэд хүндрэлтэй байна. Гэхдээ гарааны компаниудад дэмжлэг үзүүлэх, инновацийн судалгаа шинжилгээний шаардлагатай технологи, дэд бүтцээр хангах, оюуны өмчийн хамгаалалт зэрэг инновацид шаардлагатай дэд бүтцийн бүхий л үйл ажиллагааг явуулдаг байна.

Төрөөс инновацийг дэмжих тухайд маш олон төрлийн дэмжлэгийн төрлүүд байх бөгөөд хамгийн чухал нь мэдээж инновацийг санхүүжүүлэх явдал байна. Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах тухайд улс бүр төрийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийн эрхийг тухайн судалгааг хийж гүйцэтгэсэн этгээдэд олгож байна.

ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ, НОМ ЗҮЙ

1. Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2018 он
3. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Улаанбаатар хот, 2020 он
4. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Улаанбаатар хот, 2020 он
5. Монгол Улсын спартап экосистемийн суурь судалгаа, Жайка, Улаанбаатар хот, 2022 он
6. Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 306 дугаар тогтоол, түүний хавсралт “Монгол Улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр 2008-2015 он”
7. Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 306 дугаар тогтоол, түүний хавсралт “Монгол Улсад инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр 2008-2015 он”
8. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 379 дугаар тогтоол “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”
9. Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 295 дугаар тогтоол “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах 2017-2025 бодлого”
10. Монгол Улсын Засгийн Газрын 1998 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 138 дугаар тогтоол, түүний хавсралт “1998-2000 онд Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”
11. Боловсрол шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл 2023-2024, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улаанбаатар хот, 2024 он
12. Боловсрол шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл 2022-2023, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улаанбаатар хот, 2023 он
13. Боловсрол шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл 2021-2022, Боловсрол, шинжлэх ухааны яам, Улаанбаатар хот, 2022 он
14. Монгол Улсын Инновацийн чиг хандлагаар хөгжүүлэх асуудалд, Л.Оюунцэцэг, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл 2018 оны 09 дугаар, Улаанбаатар хот, 2018 он
15. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, Н.Мөнхөө, 2022 он
16. Инновацийн системийн оролцогч талуудтай хийсэн ярилцлагын судалгааны үр дүн, Н.Сонинтамир, Улаанбаатар хот, 2020 он
17. Бизнесийн байгууллага дахь инновацийн төрөл ба хууль эрх зүйн орчны нөлөөлөлд хийсэн судалгаа, Н.Сонинтамир, Н.Оюунжаргал, Н.Батдэлгэр, Д.Батхуяг, Бизнес ба инноваци, 2018 он
18. Монгол Улсад бизнесийн байгууллагын инновацийн өнөөгийн байдал, судалгааны үр дүн, Т.Пүрэвхүү, Д.Батхуяг, Н.Сонинтамир, Социологи, 2019 он
19. Шинжлэх ухаан технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2023 он

20. “Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого”, Боловсрол, Шинжлэх ухааны яам, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар хот, 2022 он
21. Боловсрол, Шинжлэх ухааны яамны 2022 оны санхүүгийн аудитын дүгнэлт, Үндэсний аудитын газар, 2023 он
22. Шинжлэх ухаан технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, Улаанбаатар хот, 2022 он
23. Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны төсөв, санхүүжилтийн тайлан, Шинжлэх ухаан, тенхологийн сан, Улаанбаатар хот, 2024 он
24. 日本の科学技術・イノベーション政策（2022 年）。
25. 研究開発法人による出資等に係るガイドライン（平成 31 年）。
26. 独立行政法人通則法の一部を改正する法律。
27. 大学等における政府資金を原資とする研究開発から生じた知的財産権についての研究ライセンスに関する指針(平成 18 年 5 月 23 日)。
28. 中华人民共和国科学技术进步法, 修订通过，自 2022 年 1 月 1 日起施行。